

Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (JICA/DPUB)

Мэдээллийн эмхэтгэл No.34 (2020.04)

DPUB төсөл онлайн цуврал хичээл зохион байгуулахаар боллоо

DPUB төсөл нь 2017 оны 10-р сараас эхлэн хөгжлийн бэрхшээлийн талаарх цуврал хичээлийг сард 1 удаа тогтмол зохион байгуулж ирсэн. Цуврал хичээл бүр ойролцоогоор 50 орчим оролцогчидтой, маш амжилттай зохион байгуулагдаж ирсэн боловч шинэ коронавирусын улмаас 2020 онд зохион байгуулагдах боломжгүй болоод байна. Гэхдээ төслийн зүгээс цуврал хичээлээ ямар нэгэн байдлаар үргэлжлүүлэх боломж байгаа эсэхийг судлаж үзсэний дүнд онлайн-аар явуулахаар боллоо.

Оролцогчид: Өмнөх цуврал хичээлүүдийн оролцогчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, холбогдох байгууллага болон хувь хүн, сонирхсон хүн бүр. Мөн хөдөө орон нутаг болон Япон улсаас ч холбогдон оролцох боломжтой.

Зорилго, ач холбогдол: Монгол улс дахь хөгжлийн бэрхшээлийн салбарын тулгамдсан асуудал, үйл ажиллагаа, ЖАЙКА-ийн хөгжлийн бэрхшээлийн салбарт хийж буй ажлууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих.

Хэзээ: Долоо хоног бүрийн мягмар, пүрэв гарагт (долоо хоногт 2 удаа).

Эхний хичээл 4-р сарын 7 (мягмар)

Цаг: 14:00~15:00 (Үргэлжлэх хугацаа 1 цаг)

Хэрхэн оролцох тухай: Лекцийг онлайн-аар явуулах ба холбогдох асуултаудад хариулт өгнө (мессеж чат хүлээж авна)
Хичээлийг DPUB Facebook хуудсаар Live-аар цацна.

Мөн доорх YouTube хуудсанд хадгалагдана.

(JICA Монгол <https://www.youtube.com/user/JICAmongolia>)

Лектор: ЖАЙКА-ийн мэргэжилтэн Чива Хисао *зарим үед зочин багш урина. (Бүх хичээл япон, монгол хэл болон монгол дохионы орчуулгатай явагдана)

Та бүхнийг хичээлд идэвхтэй оролцохыг урьж байна.

Япон дахь сургалт эхэллээ !

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” сэдвийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа багийн сургалт маань Япон улсын Токио хотод өнөөдрөөс эхэлж байна.

Сургалтын өмнө удирдамж авч байгаа манай оролцогчид бүгдээрээ маш идэвхтэй байгаа нь. (Уучлаарай. Ер нь бол дандаа идэвхтэй байдаг л даа)



Энэ удаагийн сургалтад төрийн байгууллагын 5 хүн, ТББ-ын 6 хүний төлөөлөл оролцож, Японы улсын нийгмийн хамгааллын тогтолцоо, хэрэгжүүлэх механизм талаар суралцахын зэрэгцээ Төр, ТББ-ууд хэрхэн уялдаа холбоотой ажиллаж байгаа талаар олж мэдсэн зүйлээ Монголдоо авч буцах болно. Өнөөдрөөс эхлэн өдөр бүр сургалтын талаарх мэдээллийг газар дээрээс нь мэдээлэх тул та бүхэн сонирхон уншаарай. (2020.01.15)

Сургалтын 3 дахь өдөр: Шинжюкү дүүргийн хөдөлмөр эрхлэгчид болон ажлын байрыг дэмжих төв дээр очиж, ХБИ-д бодит байдал дээр ямар үйлчилгээг хэрхэн өгч байгаатай танилцлаа. Тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих А,Б гэсэн 2 хэлбэр, энгийн хөдөлмөр эрхлэлт рүү



Үйлчилгээтэй танилцаж буй үйл явц

шилжих завсрын үеийн дэмжлэг, ажил болон сургалтын хэлбэр, хөнгөн ажил, ИТ, цэвэрлэгээний ажлын талаар мэдээлэл авлаа. Шинжюкү дүүргийн хувьд бие даан хэрэгжүүлж байгаа бөгөөд хуульд зааснаас гадна орон нутгийн засаг захиргааны хувьд санаачлан хэрэгжүүлж байгаа энэхүү үйл ажиллагаа нь оролцогчдод гүнзгий сэтгэгдэл төрүүлж байлаа. Үдээс хойш Токиогийн олон улсын онгоцны буудал (Ханэда) -тай

танилцлаа. Тус буудлын олон улсын терминал нь дэд бүтцийн хүртээмжээс гадна үйлчилгээ, дэмжлэгийн хувьд ч маш сайн. Төрөл бүрийн хэрэглээг хангасан ариун цэврийн өрөө, таблет ашигласан дохионы хэлний орчуулга, олон хэл дээрх мэдээлэл, харилцаа холбоо, тэргэнцрээр зорчих үйлчилгээ гэх мэт цаашдаа Монголын шинэ нисэх онгоцны буудалд ч гэсэн бий болоосой гэмээр олон үйлчилгээ байсан. Манай оролцогчид шинэ нисэх онгоцны буудлыг ийм болно гэж найдаж байгаагаа хэлж байлаа.



Сургалтын оролцогчид

Сүүлийн үеийн мэдээллийг доорх хуудсаар орж уншина уу.

<https://www.facebook.com/jicadpub/>

Сургалтын 6 дахь өдөр: Японы бие даан амьдрах төвийн төлөөлөл болсон Human care холбоон дээр очиж үйл ажиллагаатай нь танилцав. Хөтөлбөрийн дагуу үдээс өмнө холбооны тэргүүн Наканиши тус төвийн үүсгэн байгуулагдсан болоод үйл ажиллагааны түүх, хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч хүн ямар



үйл ажиллагаа явуулах талаар сонирхолтой илтгэл тавьлаа. Япон төдийгүй Азийн орнуудад Бие даан амьдрах төвийг түгээн дэлгэрүүлэх ажлыг хийж ирсэн Наканиши тэргүүний

хийсэн ажил, туршлага Монголын оролцогчдод гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн болов уу. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэн бие даан амьдрахад шаардлагатай хувийн туслахын тогтолцоо, засгийн газрын татаас гэх мэт цаашид Монголд хэрэг болох мэдээллийг олж авч чадлаа. Үдээс хойш тус төвийн үйлчлүүлэгч Үчиёмагийн гэрт очиж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн хэрхэн бие даан амьдарч байгаатай танилцав. Асрамжийн газраас гарч орон нутагтаа ганцаараа бие даан амьдрах хүртэл 2 жил бэлдсэн талаарх яриа оролцогчдын сонирхлыг татаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн бие даасан амьдралын хэв маягт шилжих хүртэл төрөл бүрийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болохыг ойлголоо. Нөгөөтэйгүүр бие даасан амьдралд шилжсэнээр түүний амьдрал өөрчлөгдсөн бөгөөд өдөр тутам маш идэвхтэй амьдарч байгаа Үчиёмагийн амдралын хэв маяг манай оролцогчдын сэтгэлийг хөдөлгөлөө. (2020.01.23)



Япон дахь сургалтын сүүлийн өдөр тус сургалтад оролцогчдын зүгээс тайлангаа тавьлаа. Тайлан ①Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ②ХБИ-ийн халамжийн үйлчилгээ, ③Бие даан амьдрах гэсэн 3 сэдвийн хүрээнд явагдлаа. 3 багт хуваагдан ①Сургалтаас олж мэдсэн зүйл, ②Монголд тулгарч байгаа асуудал, ③Цаашид авах арга хэмжээ, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар тайлан тавив. Багийнхан маань очигдрөөс хэлэлцүүлэг явуулж, Монголд байгаа зүйлс болоод учир дутагдалтай байгаа асуудал, цаашид шаардлагатай арга хэмжээний талаарх ойлголтоо нэгтгэн тайлангийн бэлтгэлээ хангасан. Тайлангийн үеэр Жайкагийн төвийн зүгээс тавьсан асуултад хариулж, оролцогчид төрөл бүрийн асуудлаар санал солилцов. Оролцогчдын тайланг сонсоод энэ удаагийн сургалт маш их ач холбогдолтой боллоо гэсэн дүгнэлтэд хүрлээ. (2020.01.27)

Шинэ замнал



Ахлах зөвлөх Чуба Хусао

Япон санд ажиллаад 5 жил болсны дараа цаашдын карьерийнхаа талаар ахин бодож эхлэв. Тэр үед би 42 настай байлаа. Энэ хэвээрээ Япон санд үлдэх үү, эсвэл өөр ажил хийх үү? Өмнө нь дурдсанчлан Тайландад ЖАЙКА-ийн мэргэжилтнээр ажиллаж байх үед туршлага чадвар дутагдаж байсан. Тиймээс Япон санд ажиллахын хажуугаар Японы нийгмийн халамжийн их сургуульд магистрт суралцаж байв. Онлайнаар лекц авч, жилд хэдхэн удаа л сургууль дээрээ очдог учраас ажиллахын хажуугаар сурч буй хүнд яг тохирсон сургууль байлаа. Би Олон улсын нийгмийн хөгжлийн судалгааны тэнхимд Хөгжиж буй орнуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн чиглэлээр суралцсан. Магистрын дипломын ажил маань “Тайланд улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлгөөний хөгжил” гэдэг сэдэвтэй байв. Дипломын ажлын сэдвээ нилээн удаж байж сонгосон бөгөөд 2 жилийн хугацаанд төгсөж чадахгүй гэж бодож байсан. Гэхдээ хэдийгээр цаг хугацаа давчуу байсан ч Тайландад судалгаа хийж, шөнө орой сууж дипломын ажлаа бичсэний үр дүнд 2 дахь удаагийн магистрын зэргээ авч чадсан юм. Энэхүү туршлага маань докторын зэрэг горилох хүслийг минь улам бүр нэмэгдүүлсэн.

DPUB Холбоо барих хаяг

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: <https://www.facebook.com/jicadpub>

Цахим хуудас: <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

И-мэйл: dpub.jica@gmail.com